



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/94

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” 10/06 дугаар тогтоолыг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн 2019 оны хөгжлийн бүтээн байгуулалт, баялаг бүтээгчдийн үйлдвэрлэл үйлчилгээ, бүтээгдхүүний сурталчилгаа мэдээллийг олон нийтийн Монголын үндэсний телевизээр нийтэд сурталчлах нэвтрүүлэг бэлтгэх ажлын хэсгийг ажиллуулах тээврийн зардалд 2,0 сая төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.


2.Тус арга хэмжээнд зарцуулах 2,0 сая төгрөг /хоёр сая/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний 5.6-д баталсан “Аймгийн ногоон хөгжлийн /2016-2026/ хөтөлбөр”-ийн арга хэмжээнээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2020 оны 02
дугаар сарын 13-ны өдрийн А/94 дүгээр
захирамжийн хавсралт



АЙМГИЙН 2019 ОНЫ ХӨГЖЛИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, БАЯЛАГ
БҮТЭЭГЧДИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
СУРТАЛЧИЛГАА МЭДЭЭЛЛИЙН ЗАРДАЛ

ДД	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо	Нэгж зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/
1.	УБ-Ховд-УБ ирж буцах унааны зардал	Хүн	3	626.000.00	1878000.00
2	Ачааны хөлс	кг	35	3500.00	122000.00
	Дүн				2000000.00

-oOo-